



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №6

Нэг. Шувууны томуугийн А хүрээний вирусийн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Унгар, Польш, Герман, АНУ, Энэтхэг, Тайвань зэрэг оронд шувуунд илрээд байна. Унгар улсад 5 удаагийн өвчлөл бүртгэгдэж 205683, Польш улсад 1 удаа өвчлөл бүртгэгдэж 200, Герман улсад 1 удаа өвчлөл бүртгэгдэж 137, АНУ-д 1 удаа өвчлөл бүртгэгдэж 1583, Энэтхэг улсад 2 удаагийн өвчлөл бүртгэгдэж 2541, Тайвань улсад 1 удаагийн тохиолдлоор 2541 тэжээмэл шувууд өвчилж үхсэн байна (хүснэгт 1, зураг 1).

Хоёр. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй.

Гурав. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй.

Дөрөв. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тав. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн байна. БНХАУ-н Гуандун мужийн 3 настай охин халдвар авсан байна. Бага зэрэг зовиуртай, шинж тэмдэг илрэхээс өмнө хүүхэд тахианы аж ахуйд ойр байсан. 2015 оноос хойш (H9N2) вирусийн хүний өвчлөлийн 30 дахь тохиолдол болж байна.

Зургаа. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


Долоо. 2020 оны 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 13-ныг хүртлэх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт болон вирусийн хэлбэр

№	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Хэлбэр	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Шувууны зүйл
1	31/03/2020	H5N8	Унгар	Сонград	141652	Нугасны аж ахуй
2	29/03/2020	H5N8	Унгар	Сонград	54000	Нугасны аж ахуй
3	27/03/2020	H5N8	Герман	Булстриген	20087	Цацагт хяруул
4	6/3/2020	H5N1	Энэтхэг	Кирала	3524	Тахианы аж ахуй
5	6/3/2020	H5N1	Энэтхэг	Кирала	13277	Тахианы аж ахуй
6	25/03/2020	H5N5	Тайвань	Хоуби	4000	Тэжээмэл галуу
7	31/03/2020	H5N8	Унгар	Рузса	4752	Тахианы аж ахуй
8	30/03/2020	H5N8	Польш	Лубуски	28938	Тахианы аж ахуй
9	22/03/2020	H5N8	Унгар	Бакс	2635	Тахианы аж ахуй
10	22/03/2020	H5N8	Унгар	Сонград	2777	Тахианы аж ахуй
11	6/4/2020	H7N3	АНУ	Өмнөд Каролин	34160	Цацагт хяруул

Эх сурвалж: Oie.int

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт /зургаар/



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ